



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 4/68

Өлгий

Г Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн эрх сунгах, түдгэлзүүлэх хүсэлтийг шийдвэрлэх тухай Г


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, 19.4 заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 5.4, 5.5, 6 дугаар зүйлийн 6.2, 8.1 дүгээр зүйлийн 13 дугаар жагсаалтын 13.12, 13.19 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шинжээчийн бүрэлдэхүүний 2025 оны 10 дугаар сарын 02-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу тусгай зөвшөөрлийн эрхийг сунгах, тусгай зөвшөөрлийн эрхийг түр түдгэлзүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулах эрүүл мэндийн байгууллагуудын жагсаалтыг хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Клиникийн бүтэц, үйл ажиллагаа MNS 6673:2017, Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага MNS 5260:2015 стандартуудыг ханган ажиллахыг тусгай зөвшөөрөл авсан эрүүл мэндийн байгууллагуудад даалгасугай.

3. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл сунгуулсан клиникт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх, үнэлгээ хийх, дүгнэлт гаргах шинжээчийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ДАУЫРЖАН



Эрүүл мэндийн газрын даргын
... оны ...10... сарын ...04... өдрийн ...17/64... тоот
тушаалын ...1-1... хавсралт



НЭГ. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ НЬ СУНГАГДСАН БАЙГУУЛЛАГУУД:

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Хүчинтэй хугацаа
1	“ЗХ-ний 340-р анги” эмнэлэг	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	5 жилээр	2030.09.20
2	“Көз айым”	Нүдний өвчний тусламж, үйлчилгээний клиник	5 жилээр	2030.10.27

ХОЁР. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЭРХИЙГ 3 САР ХҮРТЭЛ ХУГАЦААГААР ТҮДГЭЛЗҮҮЛЭХ:

1. Өлгий сум 5-р баг “КосКос” ХХК-ийн “КосКос” эмийн сан
2. Өлгий сум 11-р баг “Мөнхийн тун” ХХК-ийн “Мөнхийн тун” эмийн сан
3. Өлгий сум 11-р баг “Бек-Сарана” Хоршоо “Ажар” эмийн сан
4. Өлгий сум 12-р баг “Бескарагай” ХХК-ийн “Дуалы” эмийн сан
5. Өлгий сум 13-р баг “Мунказ” ХХК-ийн “Мунказ” эмийн сан
6. Өлгий сум 5-р баг “Шуах” ХХК-ийн “Марал” хүүхэд, нярайн эмнэлэг

ГУРАВ. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ:

1. “Нурлы” ХХК-ийн “Нурлы” эмийн сан шинэ орон байранд нүүх хүсэлт.
2. “Ер Фа Ай Ар” ХХК-ийн “Могойт 2” эмийн сангийн эрхлэгч Б.Аймэлдир өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тул С.Лашынийг эрхлэгчээр ажиллуулах хүсэлт.